



АНД-ЭНЕРГИ ХУВЬЦААТ  
КОМПАНИ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН  
2021

Утас: 88351298, 77711010

E-mail: [info.andenergy@gmail.com](mailto:info.andenergy@gmail.com)

ОРХОН АЙМАГ

## АГУУЛГА

### 1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий танилцуулга.....	3
1.2. Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, үйл ажиллагааны зарчим.....	4-5
1.3. Бүтэц, зохион байгуулалт.....	5
1.4. Бүтэц зохион байгуулалтад гарсан өөрчлөлтүүд.....	6
1.5. Сургалт хөгжил.....	7

### 2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2.1. Онцлох үйл явдлууд.....	8-15
2.2. Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ арга барил, техник, технологи.....	15-18
2.3. Шагнал урамшуулал.....	19
2.4. Санхүү, үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд.....	20-25

### 3. БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Гэрэлтүүлгийн салбарын тухай.....	26
3.2. Бүтээгдэхүүн.....	27
3.3. Бидний харилцагчид.....	28

### 4. КОМПАНИЙН ЗАСАГЛАА

4.1. Засаглалын тогтолцоо.....	29
4.2. Хувьцаа эзэмшигчид.....	30
4.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал.....	30
4.4. Төлөөлөн удирдах зөвлөл.....	31-32
4.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн.....	33
4.6. Эрх бүхий албан тушаалтнууд.....	34-36
4.7. Хөрөнгийн зах зээл, хувьцааны арилжаа.....	37-38

### 5. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

5.1. Хараат бус аудиторын тайлан.....	39-41
5.2. Санхүүгийн байдлын тайлан .....	42
5.3. Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	43
5.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	44
5.5. Мөнгөн гүйлгээний тайлан.....	45

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА


КОМПАНИЙН ОНООСОН НЭР	Анд-Энерги ХК
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	<ul style="list-style-type: none"><li>- LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл</li><li>- Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ</li><li>- Үйлдвэрлэлийн автоматжуулалт</li><li>- Гадаад худалдаа</li></ul>
АЛБАН ЁСНЫ ХАЯГ	<p>Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян-Зам 3-4, 6 тоот</p> <p>Утас: 77711010 И-мэйл: <a href="mailto:Info.andenergy@gmail.com">Info.andenergy@gmail.com</a> Вэб сайт: <a href="http://www.andenergy.mn">www.andenergy.mn</a> Фейсбүүк: And energy</p>
КОМПАНИЙН УДИРДАГА	<p>ТУЗ-н дарга: Далхаагийн Мөнхбаяр Гүйцэтгэх захирал: Цэнд-Аюушийн Гүррагчаа</p>
ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ОГНОО	2011 оны 5-р сарын 23 өдөр
АЖИЛЧДЫН ТОО	36
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХУЧИН ЧАДАЛ	Өдөрт 500-800 гэрэл үйлдвэрлэх
ДЭЛГҮҮРИЙН ТОО	<p>Орхон аймаг-1: Үйлдвэрийн байранд Улаанбаатар хот-1: Мишээл Барилгын Их дэлгүүрийн 2 давхарт 87-р павильон</p>

## 1.2. ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ



## 1.3. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн бүтэц, зохион байгуулалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 07 тоот тогтоолоор шинэчлэн баталсан. Уг бүтэц зохион байгуулалтын дагуу 4 алба, 37 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.




## ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Компанийн үйл ажиллагааны зан төлөвт тохирсон хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх замаар мэргэшсэн менежментийн болон ИТА-г бий болгон, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Ажилчдын мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, өсөн дэвших боломжийг бүрдүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд цахим хэлбэрээр сургалтуудад хамруулж байна.
- Ажлын үзүүлэлтийг үнэлэх журмын дагуу бүтээмжид суурилсан нэмэлт урамшууллыг олгож байна.
- Судалгаа хөгжлийн багийг шинээр бүрдүүлж, бүтээгдэхүүн хөгжүүлэх, хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, шинээр үндэсний өв соёлыг хадгалсан бүтээгдэхүүн бий болгохоор ажиллаж байна.
- Бид ажилтнаа тогтвор суурьшилтай, урт хугацаанд бүтээмжтэй ажиллуулах, нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор удаан жил ажилласны нэмэлт урамшуулал, ур чадварын нэмэгдэл цалинг олгож эхлээд байна.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цаашид байгууллагын хэмжээнд цагийн ажлыг бий болгох, хүний нөөцийг бэлтгэх зорилгоор 4 ажилтны түр ажлын байрыг бий болгон, цаашид байнгын ажлын байраар ханган ажиллахаар зорьж байна.

## 1.4. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

2021 онд Нийт 37 хүн ажиллах бүтцийн орон тоотойгоор бизнес төлөвлөгөөнд тусган баталж, Өнөөгийн байдлаар нийт 36 хүн ажилаж байна. Үүнд:



## 1.5. СУРГАЛТ ХӨГЖИЛ

### ONLINE СУРГАЛТ

Ковид-19 онцгой нөхцөл байдлын улмаас цахим сургалтуудад суух боломж бүрдэж Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан дараах сургалтуудад ажилчдаа суралцуулсан. Үүнд:

- ✓ Стратегийн менежмент
- ✓ Санхүүгийн удирдлага
- ✓ Маркетинг
- ✓ Хүний нөөц
- ✓ Менежментийн загварчлал
- ✓ Үйлдвэрлэлийн удирдлага
- ✓ Дэлгүүрийн удирдлага зэрэг сургалтуудад менежментийн багийн гишүүдийг сургаж, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэв.



Шнайдер Электрик компаниас зохион байгуулсан автоматжуулалтын сургалтад хамрагдсан.



Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсээс зохион байгуулсан „MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоо” сургалтад суусан.

### МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ

Германы „GIZ” -ийн Progress төслийн захиалгаар „Содура консалтинг” ХХК -аас зохион байгуулсан Орхон аймгийн бизнес эрхлэгчдийг чадавхижуулах сургалтуудад менежментийн багаараа суралцан, мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн. Үүнд:



- ✓ 5S-ийг хэрэгжүүлэх сургалт
- ✓ Чанарын удирдлагын сургалт
- ✓ Бизнес төлөвлөгөө боловсруулах, зөвлөх сургалт
- ✓ Бизнесийн оношилгоо, шинжилгээ хийх
- ✓ Стратеги төлөвлөлт, бизнес төлөвлөгөө.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### 2.1. ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

#### ГЭРЭЛТҮҮЛГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

80 нэр төрлийн 21,914 ширхэг ГЭРЭЛ үйлдвэрлэв.



Дотор гэрэлтүүлэг  
20381



Гадна гэрэлтүүлэг  
1487



Гэрэлтдэг үсгэн хаяг  
196



Гэрэлтүүлгийн шон  
59



ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУДЫН ТАНИЛЦУУЛГА

АВТОМАТЖУУЛАЛТЫН АЖИЛ - 1

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ” -н Ус хангамжийн цехийн EBARA насоснуудын удирдлага, хяналтын системийг шинэчлэх ажлыг дуусган хүлээлгэж өгөв.




ЦАХИЛГААН УГСРАЛТ, СУУРИЛУУЛАЛТЫН АЖИЛ - 1

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 6-0,4кв-н цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажлыг Ричвелл ХХК -тай хамтран гүйцэтгэв.



ГУДАМЖ ТАЛБАЙН ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ - 5

НАРАН, СОГООТ багийн гэрэлтүүлгийн ажилд 14 ширхэг гэрэлтүүлгийн шон суурилуулан улсын комисст хүлээлгэн өглөө.



Булган аймгийн  
Бүрэгхангай сумын төвийн  
зам дагуу шинээр 19  
ширхэг гэрэлтүүлгийн шон  
суурилуулан, хуучин  
гэрэлтүүлгийг засварлав.



“ЭРДМИЙН САН  
СУРГУУЛЬ” –ийн гадна  
талбайн 5 ширхэг  
гоёлын шонтой  
гэрэлтүүлгийг  
суурилуулав.



### ДОТОР ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ - 10

“Орхон молл”  
худалдаа үйлчилгээний  
төвийн дотор 658 ширхэг  
гэрэлтүүлгийг суурилуулах  
ажлыг гүйцэтгэв.



Хөдөлмөр зуслангийн  
монгол гэр доторх  
гэрэлтүүлгийн ажлыг  
хийж гүйцэтгэв.



### ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ - 3

Ерөнхий боловсролын 4-р  
сургуулийн 2 давхрын  
коридорт 24 ширхэг  
гэрэлтүүлгийг суурилуулж,  
эрчим хүчний хэмнэлтийг  
тооцов.



#### Төслийн үр дүн

1. Орчны гэрэлтүүлгийн хэмжээ 1.4-1.6 дахин нэмэгдсэн.
2. Гэрэлтүүлгийн чадал 1.8 дахин буурсан.
3. Гэрэлтүүлэг сольсон хэсэгт 1 жилд 1,658.9 кВт цахилгаан эрчим хүчийг хэмнэнэ.
4. Эдийн засгийн хувьд 1 жилд 233,222 төгрөгийг хэмнэнэ.

Ерөнхий боловсролын 5-р  
сургууль Биологийн  
кабинетад 15 ширхэг  
гэрэлтүүлгийг  
суурилуулав.





**Төслийн үр дүн**

1. Орчны гэрэлтүүлгийн хэмжээ 2.2-3 дахин нэмэгдсэн.
2. Гэрэлтүүлгийн чадал 3.5 дахин буурсан.
3. Гэрэл сольсон хэсэгт 1 жилд 3,141.6 кВт эрчим хүчийг хэмнэнэ.
4. Эдийн засгийн хувьд 1 жилд 441,678 төгрөгийг хэмнэлт бий болно.

Ерөнхий боловсролын  
17-р сургуулийн 1 давхрын  
коридорт 14 ширхэг  
гэрэлтүүлгийг  
суурилуулан, эрчим  
хүчний хэмнэлтийг тооцов.



**Төслийн үр дүн**

1. Орчны гэрэлтүүлгийн хэмжээ 2.1-2.4 дахин нэмэгдсэн.
2. Гэрэлтүүлгийн чадал 2.3 дахин буурсан.
3. Гэрэл сольсон хэсэгт 1 жилд 889.6 кВт эрчим хүчний хэмнэлт гарна.
4. Эдийн засгийн хувьд 1 жилд 125,069 төгрөгийг хэмнэнэ.

**ҮСГЭН ХАЯГ**

Булган аймаг дахь  
“Хөдөлмөр халамж  
үйлчилгээний газар” -ын  
гэрэлтдэг үсгэн хаяг  
логог хийж суурилуулав.



“ЭРДМИЙН САН СУРГУУЛЬ” –ийн гэрэлтдэг үсгэн хаяг хийж гүйцэтгэв.



Ерөнхий боловсролын 4-р сургуульд Монгол ахуйг бэлгэдсэн үзүүлдэнд „Өлзий хээ” гэрэлтдэг таазны гэрэлтүүлгийн хийж суурилуулав.



“Цонх хаалга, шилэн пасад” гэрэлтдэг үсгэн хаягийг хийж гүйцэтгэв.



“Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-н Зураг төслийн хүрээлэнгийн гадна үсгэн хаягийг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэв.



Эрдэнэт Мах маркет ХХК-ийн гэрэлтдэг үсгэн хаягийг Орхон мол ХҮТөв, болон компанийн байранд суурилуулав.



“Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-н Эрдэнэт сувилал, клиникийн гэрэлтдэг үсгийн хаягийг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөв.



Орхон аймгийн “LPG Lotus salon”-ийн гэрэлтдэг үсгэн хаягийг суурилуулав.



Орхон аймгийн цэцэрлэгт хүрээлэнгийн үсгэн хаягийг суурилуулав.





“Байгаль орчин, аялал жуулчлалын газар”-н мэдээллийн самбарыг хийж гүйцэтгэв.




НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

Орхон аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусыг хөгжүүлэх “Найдвар төв”-ийн 20 жилийн ойд зориулан Light box, мэдээллийн самбарыг хийж суурилуулав.



2.2. ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ АРГА БАРИЛ

Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын дотоод үйл ажиллагааг процессжуулан ажимаж эхлээд байна.



Эрчим хүчний зохицуулах хорооны 352 тоот тушаалаар 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс “Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага” болж магадлан ИТГЭМЖЛЭГДЛЭЭ.



### ГЭРЭЛТҮҮЛГИЙН ГОСТ СТАНДАРТУУДЫГ СУНГАВ.

Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журмын дагуу 2020 оны 4 сараас ГОСТ стандартуудыг үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн билээ. ГОСТ стандартын хүчин төгөлдөр байх хугацааг нэг жилээр сунгалаа.





**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ХУГАЦААГ СУНГАВ.**

Эрчим хүчний яамны  
0.4-35 кВ-ын цахилгаан  
дамжуулах шугам, дэд  
станцын угсралт, засварын  
ажил, түүний туршилт  
тохируулгын ажил  
үйлчилгээ үзүүлэх тусгай  
зөвшөөрлийг 5 жилийн  
хугацаагаар сунгаж  
баталгаажуулаа.




**ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**ЦАХИМ ҮЗЭСГЭЛЭН**

ЖДҮ газраас зохион  
байгуулагдсан "ЭХ ОРОНЧ  
ХУДАЛДАН АВАЛТ  
ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ-  
2021" ONLINE EXPO цахим  
үзэсгэлэнд Анд-Энерги ХК-  
ийн цахим BOOTH-ыг  
үүсгэн 2021.04.01-нээс  
05.01-н хүртэлх хугацаанд  
амжилтай оролцсон.



Ард аппликейшн нь Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн арилжааны системтэй холбогдсоноор иргэд гар утсаараа хандан Анд-Энерги ХК-ийн хувьцааг арилжих боломжтой болсон.



### "Эрдэнэт хот 45" 45 инженерийн зөвлөгөөн

Эрдэнэт хотын 45 жилийн ойд зориулан зохион байгуулсан Орхон аймгийн инженерүүдийн зөвлөгөөнд оролцон, олон нийтийг хамарсан үзэсгэлэнд амжилттай оролцсон.



2.3. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Орхон аймгийн  
“Шилдэг татвар төлөгч  
байгууллага”



Орхон аймгийн  
“Хэрэглэгчдийн  
найдвартай түнш  
байгууллага”



Орхон аймгийн Баян-  
Өндөр сумын ИТХ-аас  
зохион байгуулсан  
ажлын байрны гадна  
тохижилт, өнгө үзэмжийг  
сайжруулах зорилготой  
“ӨНГӨЛӨГ ЭРДЭНЭТ  
ХОТ” аянд амжилттай  
оролцов.





## 2.4. САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2018	2019	2020	2021
Гэрлийн жижиглэнгийн борлуулалт	сая.төг	30.8	54.1	67.2	127.8
Гэрлийн бөөний борлуулалт		884	869.4	859.6	839.1
Цахилгаан тоног төхөөрөмж худалдаа				535.8	512.6
Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт , Автоматжуулалтын ажил			456.5	408.9	325.8
Гэрэлтүүлгийн угсралт суурилуулалт				244.7	77.9
Анд-Маркет (хүнс, кофе шоп)				89.6	147.6
<b>Нийт борлуулалтын орлого</b>			<b>914.8</b>	<b>1,380.0</b>	<b>2,205.8</b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	597.3	880.2	1313	1266.5
Үйл ажиллагааны зардал		280.54	377.6	893.4	765
Цэвэр ашиг		32.4	22.1	24.5	13.8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТ</b>					
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо	ширхэг	34,472	25,699	25,731	21,914
Борлуулсан бүтээгдэхүүний тоо (үйлдвэрлэн)		31,129	22,448	37,243	21,690
Үйлдвэрлэлийн хүчин чадал		150-300	300-500	500-800	500-800
Ажил			11	8	17
Цахилгаан тоног төхөөрөмж нийлүүлэлт					3

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД






САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




**ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ**

ТӨСӨВТ НИЙТ 383.59 сая.төг-ний ТАТВАР ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭЭД БАЙНА.



**ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ**





Хүний нөөцийн ашиглалтын үзүүлэлт

Дансны дундаж ажилчдын тоо **36**

Ажлаас гарсан шалтгаан	Нийт хүний тоо
<b>1. Зайлшгүй эргэлтийн коэффициент</b>	<b>19.44%</b>
Дүн	7
Цомхотгол орсон	0
Гадаадад суралцахаар явсан	0
Цэрэгт явсан	0
Хөдөлмөрийн чадвараа алдсан	1
Өөр газар луу шилжсэн	1
Бусад зайлшгүй шалтгаан	5
<b>2. Тогтворгүй байдлын коэффициент</b>	<b>13.89%</b>
Дүн	5
Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан	4
Хөдөлмөрийн сахилга зөрчиж халагдсан	1
<b>3. Хүний нөөцийн гаралтын коэффициент</b>	<b>33.33%</b>
<b>4. Хүний нөөцийн оролтын коэффициент</b>	<b>22.22%</b>
Дүн	8
Шинээр ажилд авсан	6
Гадаадад суралцах хугацааны чөлөөнөөс орсон	0
Цэргээс ирсэн	0
Өөр газраас шилжиж ирсэн	2
Бусад	0
<b>5. Хүний нөөцийн тогтворжилтын коэффициент</b>	<b>72.73%</b>

Ажилчдын нийт тоо	36	
<i>Үүнээс: Хүүхэд асрах чөлөөтэй 5 хүн байна.</i>		
Хүйс		
Эр	16	44%
Эм	20	56%
Нас		
25 >=	8	22%
26-35	16	44%
36-45	5	14%
46-55	6	17%
56 =<	1	3%

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1. ГЭРЭЛТҮҮЛГИЙН САЛБАРЫН ТУХАЙ

LED гэрэл гэрэлтүүлгийн үйлдвэрлэл борлуулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй тогтмол өсөж байна. Улайсдаг гэрэлтүүлгээс LED гэрэл цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй байдаг нь байгууллага, өрхийн сонголтод эерэгээр нөлөөлж байна. 2019 оны мэдээгээр дэлхийн зах зээлийн хувьд 35 орчим тэрбум ам.доллар бөгөөд 2023 онд 45 тэрбум ам.доллар, 2030 онд 84 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгааг судлаачид илэрхийлж байна. 2024 он гэхэд LED гэрэл гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн хэрэгсэл үйлдвэрлэгчид жилдээ 28% -ийн ашиг олно гэж төлөвлөж байна. LED чип үйлдвэрлэгчид Үүнд:

1. Everlight Electronics
2. GYLE
3. Lite-on Technology
4. Mitsubishi
5. Osram
6. Epistar – диод
7. GE
8. Philips зэрэг үйлдвэрлэгчид байна.



Манай компани Epistar брендийн диодыг үйлдвэрлэлдээ ашиглаж байна.

#### Дотоод зах зээл

Манай улсын LED технологи, гэрэл гэрэлтүүлгийн зах зээл импортын бүтээгдэхүүнээс хамааралтай байдаг. Гэрэл гэрэлтүүлгийн зах зээлийн хувьд импортын гэрлийн 90 хувь нь БНХАУ-аас хамааралтай байгаа бөгөөд борлуулалтын дараах сувгуудаар борлуулагдаж байна. Үүнд

- ✓ Барилгын материалын төрөлжсөн худалдааны төв, дэлгүүр
- ✓ Онлайн худалдаа
- ✓ БНХАУ-ын үйлдвэрлэгч нарын төлөөлөгчийн газар, гэрээт дэлгүүр

Гэрэл хэрэглэгч нь байгууллага, хувь хүн бөгөөд дотор, гадна талбайд ашиглаж байна. Манай улсад бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 95,2 мянган аж ахуй нэгж, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан 908,7 мянган өрх гэрэл гэрэлтүүлэг хэрэглэж байна. Эдгээр хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн ашиглалтын хугацаа урттай, орчин үеийн интериорын шийдэлд тохирсон загвар хийцтэй гэрэл үйлдвэрлэн, борлуулалтын оновчтой суваг сонгон, үр дүнтэй маркетингийн арга хэрэгсэл ашиглан борлуулалтаа нэмэгдүүлэх, зах зээлээ өргөтгөх боломжтой юм.

**3.2. БҮТЭЭГДЭХҮҮН**



**LED Чийдэн**  
Зориулалт: Ахуйн хэрэглээний  
Чадал: 5Вт, 7Вт, 9Вт, 12Вт  
Цагаан, шар туяатай



**LED Нүдэн гэрэл**  
Зориулалт: Ахуйн хэрэглээний  
Чадал: 3Вт, 5Вт  
Бүрхүүлийн сонголттой

**LED Candle гэрэл /Абжурны/**  
Зориулалт: Ахуйн хэрэглээний  
Чадал: 5Вт  
Гадна бүрхүүлийн сонголттой



**LED Нүдэн гэрэл**  
Зориулалт: Ахуйн хэрэглээний  
Чадал: 3Вт, 5Вт  
Гадна бүрхүүлийн сонголттой



**LED Прожектор**  
Зориулалт: Гадна гэрэлтүүлэг  
Чадал: 50Вт, 100Вт, 150Вт  
Хүчдэл: 85-265В



**LED Түмпэн гэрэл**  
Зориулалт: Үйдвэрийн /IP65/  
Чадал: 50Вт, 100Вт, 150Вт  
Хүчдэл: 85-265В

**LED T8 төрлийн суурьтай гэрэл**  
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг  
Чадал: 9Вт, 18Вт, 36Вт  
Хүчдэл: 85-265В



**LED T8 төрлийн суурьгүй гэрэл**  
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг  
Чадал: 9Вт, 18Вт, 22Вт  
Хүчдэл: 85-265В



**LED Толгой гэрэл**  
Зориулалт: Гадна гэрэлтүүлэг  
Чадал: 120Вт, 150Вт, 180Вт  
Хүчдэл: 85-265В



**LED Толгой гэрэл**  
Зориулалт: Гадна гэрэлтүүлэг  
Чадал: 50Вт, 60Вт, 80Вт, 100Вт  
Хүчдэл: 85-265В

**LED таазны гэрэл /C32/**  
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг  
Чадал: 32Вт  
Хүчдэл: 85-265В



**LED Таазны гэрэл /Панел/**  
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг  
Чадал: 48Вт  
Хүчдэл: 85-265В



**LED Малчны гэрэл**  
Зориулалт: Ахуйн хэрэглээний  
Чадал: 10Вт  
Туяаны /өнгө/ сонголттой  
Хүчдэл: Тогтмол 12В



**LED Аялалын гэрэл**  
Зориулалт: Ахуйн хэрэглээний  
Чадал: 3Вт  
Хүчдэл: Тогтмол 5В


3.3. БИДНИЙ ХАРИЛЦАГЧИД



## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### 4.1. ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

“Анд-Энерги” ХК нь хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын сонирхлын тэнцвэрийг хангах, компанийн үйл ажиллагааны бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэгдсэн дараах засаглалын бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.




Манай компани Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, гаднын компаниудын сайн засаглалын туршлагаас суралцан Сайн засаглалыг нэвтрүүлэх, компанийн засаглалаар манлайлахаар чармайн ажиллаж ирсэн бөгөөд Компанийн засаглалыг хөгжүүлэх ажлын хүрээнд Монголын хувьцаат компаниудын холбоо ТББ-ийн гишүүнээр элсэн харилцан туршлага солилцон ажиллаж байна.

*Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах журмуудыг мөрдөн ажиллаж байна.*

- ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
- ✓ Аудитын хорооны журам
- ✓ Нэр дэвшүүлэх хорооны журмыг шинэчлэн батлах
- ✓ Цалин, урамшуулмын хорооны журмыг батлах
- ✓ Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журам батлах
- ✓ Мэдээллийн үйл ажиллагааны журам.



## 4.2. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО  
**78 070 758**

НИЙТ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ТОО  
**427**

/2021.04.05-ны өдрийн байдлаар/

## 4.3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдсан. 2021 оны 04 дүгээр сарын 05-ны хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийн байдлаар нийт 427 хувьцаа эзэмшигч „Анд-Энерги“ ХК-ийн 78 070 758 ширхэг хувьцааг эзэмшиж байгаагаас ээлжит хуралд 69.21% буюу 54 033 700 ширхэг хувьцааг эзэмшдэг 36 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц бүрдэн Компанийн тухай хуулийн 69.1-т заасны дагуу хурал хүчин төгөлдөр болсон. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэсэн. Үүнд:

- ✓ Анд-Энерги ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав.
- ✓ Анд-Энерги ХК-ийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Хараат бус аудитын тайлан дүгнэлтийг батлав.



#### 4.4. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах ердийн болон хараат бус гишүүд шинээр сонгогдож, 2020 оны 5 дугаар сараас эхлэн доорх шинэчилсэн баг бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

##### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХОРООД

###### *Нэр дэвшүүлэх хороо*

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. Нэр дэвшүүлэх хорооны даргаар Д.Энхбаяр, гишүүдээр Д.Мөнхбаяр, Д.Алтангэрэл нар сонгогдон ажиллаж байна.

###### *Цалин урамшуулмын хороо*

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулмын хорооны зорилго нь компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын цалин урамшуулмыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшуулмын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. Цалин урамшуулмын хорооны даргаар Д.Мөнхбаяр, Т.Барс, Г.Түвшин, Ш.Сансарсайхан нар сонгогдон ажиллаж байна.

###### *Аудитын хороо*

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын няглан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын няглан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн үр чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Аудитын хорооны даргаар М.Ганбат, гишүүдээр С.Даваасамбуу, М.Сарандаваа нар сонгогдон ажиллаж байна.

Аудитын хороо 4 удаа хуралдаж хорооны 3 тогтоол гарган компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч дэмжин ажилласан байна.

Мөн маркетинг борлуулалтын албаны борлуулалтыг нэмэгдүүлэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал санаачлага гарган танхимаар сургалт орж компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИМЛАГАА

2021 онд Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 9 удаа хуралдаж, 19 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн, ТУЗ-ийн 19 тогтоол гарган компанийн үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажилласан байна.



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны ажлын төлөвлөгөөний биелэлт нь оны эцсээр 86.2 хувийн биелэлттэй байсан бол зардлын төсвийн гүйцэтгэл нь 98.3 хувийн зарцуулалттай тус тус байсан байна.



## 4.5. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



**Далхаа  
МӨНХБАЯР**

ТУЗ-ийн дарга  
/Цалин урамшуулмын хорооны дарга/  
/Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/



**Төмөрбат  
БАРС**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
/Цалин урамшуулмын хорооны гишүүн/  
„Анд-Энерги“ ХК  
Ерөнхий инженер



**Ганхуяг  
ТҮВШИН**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
/Цалин урамшуулмын хорооны гишүүн/  
„Эрдэнэт Үйлдвэр“ ТӨҮГ  
Автоматикийн ажлаах инженер  
багш



**Шура  
САНСАРСАЙХАН**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
/Цалин урамшуулмын хорооны гишүүн/  
„Эрдэнэт Үйлдвэр“ ТӨҮГ  
„Эрдэнэт цогцолбор“ сургуульд ажлаах



**Сандуйжав  
ДАВААСАМБУУ**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
/Аудитын хорооны гишүүн/  
Монголын үнэт цаасны клирингийн төв АЦХ  
Клиринг эрсдэлийн удирдлагын  
албаны захирал



**Дагвалунцаг  
АЛТАНГЭРЭЛ**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
/Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/  
ХХК  
Гүйцэтгэх захирал

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



**Мөнхжаргал  
ГАНБАТ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
/Аудитын хорооны дарга/  
Орхон аймаг дахь Худалдаа Аж  
Үйлдвэрийн танхимын дарга



**Мянганбуу  
САРАНДАВАА**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
/Аудитын хорооны гишүүн/  
Повер солюшн ХХК  
Гүйцэтгэх захирал



**Даваасүрэн  
ЭНХБАЯР**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
/Нэр дэвшүүлэх хорооны дарга/  
Мөнх Үржих ХХК  
Бизнес хөгжүүлэх зөвлөх

#### 4.6. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД



ЦЭНД-АЮУШ ГҮРРАГЧАА  
Гүйцэтгэх захирал

УУЛ УУРХАЙН ЦАХИЛГААН МЕХАНИК ИНЖЕНЕР

ШУТИС-ийн УУС-г Уул уурхайн цахилгаан механик инженер мэргэжлээр төгссөн, магистр зэрэгтэй.

Эрдэнэт үйлдвэр ХХК-д цахилгаанчин, тохируулгын инженер, цахилгаан механикаар ажиллаж байсан.

2011 онд Анд-Энерги ХХК-г үүсгэн байгуулж, Ерөнхий инженер, 2017 оноос одоог хүртэл Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



ТӨМӨРБАТ БАРС  
Ерөнхий инженер

УУЛ УУРХАЙН ЦАХИЛГААН МЕХАНИК ИНЖЕНЕР

ШУТИС-ийн УУС-г Уул уурхайн цахилгаан механик инженер мэргэжлээр төгссөн, магистр зэрэгтэй.

Эрдэнэт үйлдвэр ХХК-д цахилгаанчин, тохируулгын инженер, ахлах инженерээр ажиллаж байсан.

2011 онд Анд-Энерги ХХК-г үүсгэн байгуулж, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга, 2018 оноос одоог хүртэл Ерөнхий инженер, Үйлдвэр эрхэлсэн даргаар ажиллаж байна.

#### 4.6. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД



ПҮРЭВДОРЖ БЯМБАСҮРЭН  
Санхүү төлөвлөлтийн албаны дарга

ДААТГАЛЫН ЭДИЙН ЗАСАГЧ

2016 онд МИУС-ийн Орхон аймаг дахь салбар сургуулийг Даатгалын Эдийн Засагч мэргэжлээр төгссөн, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

2016-2019 онуудад СҮҮ ХК-ийн Эрдэнэт салбарт борлуулалтын менежер

2019 онд Анд-Энерги ХК-д борлуулалтын менежер

2020 онд Маркетинг, борлуулалтын албаны дарга

2021 оноос СТА-ны дарга



ЧАГНААДОРЖ САРАНЗАЯА  
Ерөнхий няглан бодогч

НЯГЛАН БОДОГЧ

2008 онд Их засаг их сургуулийг няглан бодогч мэргэжлээр төгссөн,

2012-2015 онуудад Петролум пордакшн ХХК-д няглан бодогч

2015-2016 онуудад Номин тав трейд ХХК-д няглан бодогч

2019 онд Анд-Энерги ХК тооцооны няглан бодогч

2019.08 сараас Анд-Энерги ХК Ерөнхий няглан бодогч

#### 4.6. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД



МЯГМАРСҮРЭН ДЭЛГЭРМАА  
Маркетинг, борлуулалтын албаны дарга  
САНХҮҮЧ

2019 онд Анд-Энерги ХК-д борлуулагч

2020 онд борлуулалтын менежер

2021 оноос МБА-ны дарга



ЭНХТУЯА НЯМГЭРЭЛ  
Хүний нөөцийн менежер  
АВТОМАТЖУУЛАЛТЫН ИНЖЕНЕР, ТӨСӨВЧИН

2013 онд ШУТИС-ийг Хөнгөн үйлдвэрийн автоматжуулалтын инженер

2018 онд ШУТИС, БАТС-д Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

2013-2016 онд Номин Холдинг ХХК, Хуванцрын үйлдвэрийн дарга

2017-2018 онд Анд-Энерги ХК-д Чанарын менежер, ХАБЭА хариуцсан ажилтан

2018-2019 онд Хангамж, төсөв хариуцсан мэргэжилтэн төсөвчин

2019-2020 СТА-ны дарга, төсөвчин

2020.08 сараас Хүний нөөцийн менежер, ЗАА дарга

#### 4.7. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

##### 2021 ОНЫ ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

№	Мэдээлийн төрөл	Огноо	
		2020	2021
1	Гаргасан хувьцааны тоо	78 070 758	
2	Компанийн зах зээлийн нийт үнэлгээ (төг)	3122 830 320 ₮	3 903 537 900 ₮
3	Арилжааны дүн (төг)	25 367 600 ₮	24 712 600 ₮
4	Арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	746 000	383 300
5	Дээд үнэ	45 ₮	85 ₮
6	Доод үнэ	26 ₮	35 ₮
7	Дундаж үнэ	34 ₮	64.47 ₮
8	Хаалтын үнэ (12 сарын 31-ний байдлаар)	40 ₮	50 ₮

##### ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



## ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТАЙЛАН МЭДЭЭ


№	Үнэт цаасны компанийн нэр	Арилжааны дүн (төгрөгөөр)
1	“Ард Секюритиз ҮЦК” ХХК	23,311,700 ₮
2	“Бумбат Алтай ҮЦК” ХХК	17,174,100 ₮
3	“Булган Брокер ҮЦК” ХХК	5,309,800 ₮
4	“Голомт Капитал ҮЦК” ХХК	1,229,100 ₮
5	“Дэлгэрхангай Секюритиз” ХХК	1,280,000 ₮
6	“Мон Сек” ХХК	950,800 ₮
7	“Зэргэд ҮЦК” ХХК	169,700 ₮

## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Компани тогтмол өсөлттэй ногдол ашгийн бодлогыг баримтална. ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан “Ногдол ашгийн бодлого”, ногдол ашиг хуваарилах журам”-д заасны дагуу Компани жил бүрийн цэвэр ашгийн 5-8 хувийг ногдол ашигт хуваарилах бөгөөд ногдол ашигт хуваарилах цэвэр ашгийн хувь хэмжээг жил бүр тогтмол нэмэгдүүлэх бодлого баримталж байсан. 2018 оны 01 сарын 21-ний өдрийн 03 тоот тогтоолоор Ногдол ашигт хуваарилах дүнг Компанийн тухайн жилийн цэвэр ашгийн 20%-иас доошгүй байхаар тогтоосон.

Компани 2018 оны 02 сарын 24-ний өдрийн 10 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 50 мөнгөний ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Нийт ашгийн 29.2 хувь буюу 39 035 411 төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ 2018 оны 05 сарын 01-ний өдрөөс тараасан.

Компани 2020 оны 02 сарын 15-ны өдрийн 02 тоот тогтоолоор Нэгж хувьцаанд 1.2 төгрөг (нэг төгрөг хорин мөнгө) -ний ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Нийт 93 684 909 төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс тараасан.





## ТАВДУГААР БҮЛЭГ.САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 5.1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



**МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК**  
 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг  
 16-р хороо, Амарсанавгийн гудамж, 12-1  
 Колорадо бизнес төв, 1 давхар, 101 тоот  
 Утас: 7013-1044 И-мэйл: info@magicgroup.mn  
 Вэб хуудас: www.magicgroup.mn  
 2022.02.17 дугаар 21-18/03/22  
 танаа \_\_\_\_\_ -ны дугаар \_\_\_\_\_ -т

**АНД-ЭНЕРГИ ХК**-ийн  
 хувьцаа эзэмшигчид

#### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

##### Дүгнэлт

Бид АНД-ЭНЕРГИ ХК ("Компани" гэх)-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томсохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

##### Тасралтгүй байдалтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

##### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын гол асуудлууд	Бидний гүйцэтгэсэн аудитын горим
<b>Татварын тооцооллын үнэн, зөв байдал</b> Ксмпанийн татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.	Татварын тооцооллын үнэн зөв, зохистой байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд: - Татварын тооцоолол ба түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого болон татварын талаарх удирдлагын байр суурь, үнэлгээг судлах, ойлгох;

АНД-ЭНЕРГИ ХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх 21-48/03/177 тоот  
Хараат бус аудиторын тайлангийн (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд	Бидний гүйцэтгэсэн аудитын горим
<p><b>Татварын тооцооллын үнэн, зөв байдал (үргэлжлэл)</b></p>	
<p>Монгол улсын татварын бодлого 2020 онд шинэчлэл хийн гол татварын багц хуулиудаа хэрэгжүүлж эхэлсэн. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Татварын хууль, журам болон практикийн туршлагатай өөрсдийн татварын мэргэжилтнүүд болон Компани ба эрх бүхий татварын албадууд хоорондын харилцааг ашиглан санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөрүүд нь зохистой эсэх, эсвэл татварын өр төлбөрийг бүртгээгүй үндэслэл шалтгааныг үнэлэх;</li> </ul>
<p>Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Компанид татварын эрсдэл байсаар байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөр болон тодруулга нь хангалттай эсэх, уг өр төлбөр нь татварын хуулийн сүүлийн өөрчлөлтүүдийн дагуу тооцоологдсон эсэх, боломжит татварын торгууль болон хүүг агуулсан эсэхийг үнэлэх.</li> </ul>

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээсэн үүрэг хариуцлагын тодорхойлолтыг Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн <http://www.magicgroup.mn/mn/uureg> вэб сайтад байршуулсан. Уг тодорхойлолт нь аудиторын тайлангийн нэг хэсэг юм.



АНД-ЭНЕРГИ ХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх 21-48/03/77 тоот  
Хараат бус аудиторын тайлангийн (үргэлжлэл)

### Бусад асуудал

АНД-ЭНЕРГИ ХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудад МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ ХХК аудит хийсэн бөгөөд Эерэг дүгнэлт илэрхийлсэн байна.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох АНД-ЭНЕРГИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



С.Мөнхбаяр  
Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер  
Мэжик Консалтинг Аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс  
2022 оны 02 дүгээр сарын 17

## 5.2. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**АНД-ЭНЕРГИ ХК  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4	13,288.5	25,659.0
Дансны авлага	5	299,802.7	197,477.2
Татвар, НДШ-ийн авлага	6	488.3	11,961.9
Бусад авлага	7	2,481.5	32,655.4
Бараа материал	8	349,216.8	619,299.3
Урьдчилж төлсөн төлбөр	9	214,732.7	
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>880,010.5</b>	<b>887,052.8</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	10	1,667,908.7	1,769,503.0
Биет бус хөрөнгө	11	67,220.3	62,988.0
Биологийн хөрөнгө	12	6,500.0	
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>1,741,629.0</b>	<b>1,832,491.0</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,621,639.5</b>	<b>2,719,543.8</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>			
Дансны өглөг	13	24,070.1	17,552.8
Татварын өглөг	14	19,185.4	46,084.5
НДШ-ийн өглөг	15	26,249.5	16,640.9
Богино хугацаат зээл	17	51,247.5	489,424.9
Хүүний өглөг	17	434.0	
Урьдчилж олсон орлого	16	22,486.5	6,985.0
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>143,673.0</b>	<b>579,688.1</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Урт хугацаат зээл	17	406,214.0	47,450.5
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>406,214.0</b>	<b>47,450.5</b>
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>		<b>549,887.0</b>	<b>627,138.6</b>
<b>Өөрийн хөрөнгө</b>			
Хувьцаат капитал	18	78,070.8	78,070.8
Нэмж төлөгдсөн капитал	18	1,470,540.8	1,470,540.8
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19	264,224.4	264,224.4
Хуримтлагдсан ашиг	20	258,916.5	279,569.2
<b>Нийт цэвэр хөрөнгийн дүн</b>		<b>2,071,752.5</b>	<b>2,092,405.2</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,621,639.5</b>	<b>2,719,543.8</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

### 5.3. ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

**АНД-ЭНЕРГИ ХК**  
**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**  
**2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
Борлуулалтын орлого /цэвэр/	21	2,030,853.7	2,205,820.7
Борлуулалтын өртөг	22	1,266,555.7	1,312,416.5
<b>Нийт ашиг</b>		<b>764,298.0</b>	<b>893,404.2</b>
Хүүний орлого			310.9
Бусад орлого	23	16,709.5	699.8
Борлуулалт, маркетингийн зардал	24	-121,180.3	-118,221.2
Ерөнхий удирдлагын зардал	25	-541,032.8	-620,070.5
Санхүүгийн зардал	26	-78,359.3	-99,372.7
Бусад зардал	27	-24,813.0	-31,697.0
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/		0.7	3.9
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз/		-198.6	
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>		<b>15,424.2</b>	<b>25,057.6</b>
Орлогын татварын зардал		-1,542.4	-502.4
<b>Нийт дэлгэрэнгүй орлогыг илэрхийлэх тайлант жилийн ашиг</b>		<b>13,881.8</b>	<b>24,555.2</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

#### 5.4. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**АНД-ЭНЕРГИ ХК**  
**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
**2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

Үзүүлэлт (мян.төг)	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020-01-01-ний үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>72,573.7</b>	<b>364,587.2</b>	<b>1,985,772.5</b>
НББ-ийн өөрчлөлт, алдааны залруулга				-15,888.5	15,888.5
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>72,573.7</b>	<b>348,698.7</b>	<b>1,969,884.0</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	24,555.2	24,555.2
Зарласан ногдол ашиг	-	-	-	-93,684.7	-93,684.7
Дахин үнэлгээний нэмэгдэл			191,650.7	-	191,650.7
<b>2020-12-31-ний үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>264,224.4</b>	<b>279,569.2</b>	<b>2,092,405.2</b>
НББ-ийн өөрчлөлт, алдааны залруулга				-34,534.5	-34,534.5
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>264,224.4</b>	<b>245,034.7</b>	<b>2,057,870.7</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				13,881.8	13,881.8
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдэл					
<b>2021-12-31-ний үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>264,224.4</b>	<b>258,916.5</b>	<b>2,071,752.5</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



## 5.5. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### АНД-ЭНЕРГИ ХК МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

	2021 МЯН.ТӨГ	2020 МЯН.ТӨГ
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,189,615.9</b>	<b>2,469,820.5</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,609,701.4	2,113,942.7
Бусад мөнгөн орлого	579,914.5	355,877.8
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,051,512.3</b>	<b>2,432,051.3</b>
Ажиллагчдад төлсөн	247,777.1	333,806.8
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	82,122.1	58,726.3
Бараа материал худалдан авахад төлсөн	1,063,032.0	1,557,529.6
Ашиглалтын зардалд төлсөн	8,818.4	6,386.6
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	32,442.1	2,226.4
Хүүний төлбөрт төлсөн	77,925.2	99,372.7
Татварын байгууллагад төлсөн	210,782.0	192,480.7
Даатгалын төлбөрт төлсөн	1,256.9	-
Бусад мөнгөн зарлага	327,356.5	181,522.2
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>138,103.6</b>	<b>37,769.2</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>7,000.0</b>	<b>310.9</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,000.0	-
Бусдад олгосон зээл мөнгөн урь-ны буцаан төлөлт	-	310.9
Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>76,900.4</b>	<b>91,326.0</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,285.0	59,007.8
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,232.2	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	58,383.2	32,318.2
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-69,900.4</b>	<b>-91,015.1</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>722,870.0</b>	<b>555,476.9</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гар-аас хүлээн авсан	722,870.0	555,476.9
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>803,443.7</b>	<b>523,094.7</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	803,443.7	438,778.3
Төлсөн ногдол ашиг	-	84,316.4
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-80,573.7</b>	<b>32,382.2</b>
Валютын ханшийн зөрүү	-	-
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-12,370.5</b>	<b>-20,863.7</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>25,659.0</b>	<b>46,522.7</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>13,288.5</b>	<b>25,659.0</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.





*Тэрэлтэй  
амьдаруулаа*

АНД-ЭНЕРГИ ХК

Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Уртын гол баг, Баян-Зам 3, 4-6 тоот

Утас: 77711010, 96101020

И-мэйл: [info.andenergy@gmail.com](mailto:info.andenergy@gmail.com)

Вэб сайт: [www.andenergy.mn](http://www.andenergy.mn)

Фейсбүүк: And energy